

АЖЛЫН БАЙРАН ДАХЬ БЭЛГИЙН ДАРАМТЛААЛЫГ ЗОГСООБ



ӨМНӨХ ҮГ

Ажлын Байран Дахь Бэлгийн Дарамтын асуудлыг хүний эрхийн зөрчил талаас нь авч үзэж, Хөдөлмөрийн Хууль, бусад холбогдох хууль, ёс зүйн дүрэм, журамд тусгуулахад нөлөөлөх зорилго бүхий уг номыг хэвлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Монголын Эмэгтэйчүүдийн Сан болон АНУ-ын CHANNEL сангийн хамт олонд гүнээ талархал илэрхийлье. Монголын Эмэгтэйчүүдийн сан нь 2006 оноос эхэлж АББД-тай тэмцэх Эвслийн үйл ажиллагааг дэмжиж ирсэн юм. Ялангуяа МОНЭС-ийн зөвлөх, АББД-тай тэмцэх Эвслийн зөвлөхөөр ажиллаж, Эвслийг тууштай дэмжсэн Н.Чинчулуунд тусгайлан гишүүдийнхээ өмнөөс талархал илэрхийлье.

Энэхүү ном нь шийдвэр гаргах түвшний эрхэмүүдэд хүрч Ажлын Байрны Бэлгийн Дарамтын улмаас хохирсон хохирогчдийн эрхийг хамгаалах, уг асуудлаас урьдчилан сэргийлэх, гэмт этгээдтэй хариуцлага тооцох эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлээсэй хэмээн манай АББД-тай Тэмцэх Эвслийн хамт олон хүсч байна

*Хүн бүр Бэлгийн Дарамтын бүх хэлбэрээс ангиг дайж,
Аюулгүй ажлын байранд ажиллаж,
сурч боловсрох болтугай.*

Б.Алтанчимэг.
АББД-тай Тэмцэх ЭТББ-уудын
Эвслийн зохицуулагч.

2014 он.
Улаанбаатар хот.

Номын текстийг боловсруулсан:

Б.Алтанчимэг
Сэтгэл судлалын ухааны магистр,
АББД-тай Тэмцэх ЭТББ-уудын Эвслийн зохицуулагч.

Зөвлөхөөр ажилласан:

Н.Чинчулуун
Хуульч, МОНЭС-ийн зөвлөх,
АББД-тай Тэмцэх ЭТББ-уудын Эвслийн зөвлөх.

Зураач: Н.Амартүвшин

Эх бэлтгэгч: Б.Чулуунбат

«Хөх Монгол принтинг» ХХК-д бэлтгэж, хэвлэв.





АББД гэж юу вэ?

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.7-д «бэлгийн дарамт» гэж бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ хэмээн заасан.

Доорх зургууд нь Ажлын байрны бэлгийн дарамтыг Үг яриагаар үйлдэж буйг илтгэж байна.





Эдгээр нь:

- ❖ Илт эвгүйцмээр бэлгийн сэдэвтэй яриа, онигоо ярих,
- ❖ Бэлгийн харилцаанд уриалсан агуулгатай яриа өдөөх,

❖ Хэвлэмэл материал
унших, доог тохуу хийх,

❖ Бэлгийн харилцаа тогтоох
тухай шалах,





- ❖ Бэлгийн сэдэлтэй ярианы амьд бай болгох, доог тохуу хийх,
- ❖ Зугаа цэнгэлийн газраар явах, буудалд орохыг удаа дараа санал болгох зэргээр илэрдэг.


БОДИТ ТҮҮХ №1

Манай удирдах албаны нэг хүн намайг байнга - чи сайхан биетэй шүү, чамайг нэг үзэх юмсан, уулзъя гэх мэт элдвээр хоргоох юм. Би нөхөртэй хүн, тийм юм байхгүй гэдгээ хэлсээр байхад ер ойлгохгүй элдэв мессэж хүртэл илгээх боллоо. Энэ бүхэн надад маш дарамттай төдийгүй орой үдшээр ч янз бүрийн мессэж утсанд явуулж байна. Нөхөр мэдчихвэл намайг хардах, буруутгах гээд сайн юм болохгүйг би мэдрээд байна. Гэр орондоо ч тайван байж чадахгүй үнэхээр дарамттай хэцүү юм... Яаж үүнийг болиулах вэ?

■ ТАЙЛБАР:

АББД-ын асуудлаарх санал гомдол мөн нэргүй санал асуулга, судалгааны дүнгээр энэ төрлийн дарамтлал өсвөр наснаас эхлээд хөдөлмөрийн бүхий л салбарт элбэг байдгийг 2005, 2008, 2010 оны судалгааны дүнгээс харж болохоор байна. Бодит байдалд дарамтанд байгаа хүн мухардалд орох, гэр бүлийн гишүүд нь хувийн тооцоо бодох/Дарамтлагчийг нөхөр, гэр бүлийн хүн нь очиж зодож гэмтээх/ ажлаа орхих, эсэргүүцвэл ааштай адсага гэх нэр зүүж ажил дээрээ ганцаардах, дуугүй өнгөрвөл дуртай хүүхэн хэмээн нэрлэгдэх тогтсон жишиг бүх насныхан, бүх салбаруудад байсаар байна. Энэ төрлийн дарамт нь зарим тохиолдолд гэр бүлийг ч үймүүлж болзошгүй байгаа ба гэр бүлийн хүндээ үнэн учраа хэлсэнийхээ төлөө нэмж дарамтлуулах, буруутгагдах, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх байдал гарсаар байна.

Дараах зургууд нь Ажлын байрны бэлгийн дарамтыг Үйл хөдлөл үзүүлэх харуулах байдлаар үйлдэж буйг харуулж байна.





Энэ хэлбэрийн дарамт нь,

- ❖ Порно зураг, сэтгүүл, хөзөр, плакат, сайт, CD, email, мессэж, бусад бэлгийн сэдэл агуулсан шинжтэй эд зүйл, дуу болон дүрс бичлэг үзүүлэх, харуулах, сонсох, илгээх, бэлэглэх,
- ❖ Зохисгүй элдэв дуу авиа гаргах,
- ❖ Гарын болон биеийн үйл хөдлөл, дохио зангаагаар илт бэлгийн харилцаанд уриалж, унтах санал тавих зэргээр илэрдэг.


БОДИТ ТҮҮХ №2

Интернэт чөлөөтэй ашиглаж дуртай мэдээллээ авах сайн талтай болсон боловч муу юм байна. Заримдаа имэйл хүлээж аваад үзэхэд, үнэхээр ичмээр эрээ цээргүй муухай сайт илгээсэн байх юм. Ер нь манай ажлын зарим этгээдүүд арай эрээ цээргүй, ёс зүйгүй. Саяхан гэртээ Face book-ээ нээлттэй үлдээгээр ажилдаа явсан хойгуур манай ажлын залуу санаа зовмоор порно зураг явуулаад чи энэ талаар юу гэж бодож байна гэж асуусан байх юм. Үүнийг хүүхэд үзчихээд -энэ юу вэ ээжээ гэхэд, би нүүр хийх газаргүй болсон. Би түүнд ийм дээрээ тулах хүртэл боломж хэзээ ч олгож байгаагүй. Түүний болж өгвөл л үг өдөж, илт анхаарал тавиад байгааг нь мэдэрдэг ч хэзээ ч нүүр өгч байгаагүй. Би хүүхдийнхээ өмнө түүгээр уучлал гуйлгаж болох уу.

■ ТАЙЛБАР:

АББД-ын энэ хэлбэр нь боловсрол сургалтын орчинд утас интернэт, дэлгэцийн төхөөрөмж ашиглагдан байнга үйлдэгдэх хандлагатай нь судалгаагаар нотлогдсон. Үүнээс болж бусад хөндлөнгийн хүнд төдийгүй үр хүүхэддээ хүртэл буруугаар ойлгогдох, нэр хүндгүй болох муу үр дагавартай. Ер нь илтээр айлгасан, ичээсэн, цочирдуулсан мэдээлэл, порно зураг, порно сайт, порно киног хувийн хаягаараа хүлээж авахыг хэн ч хүсэхгүй, ёс зүйн хувьд хүлээн авахгүй, дорможлогдсон мэт сэтгэгдэлтэй үлддэг байна.

Дараах зургууд нь Ажлын байрны бэлгийн дарамтыг Биеэр үйлдэж буйг илтгэж байна.



Өчигдөр манай курсийн нэг харахад номын байрын залуу хөхнөөс базаад авсан яаж ч бодсон тэр санаатай үйлдэл байсан тэгснээ санаандгүй хүрсэн гээд, Би ямар сургуулиар нэг хашгирч олны анхаарал таталтай биш дуугүй л өнгөрөөдөг.



Халуунд ямар дээл өмсөлтэй биш. Ингэж хувцасласан нь бидний буруу биш биз дээ






Эдгээр нь:

- ❖ Биед зохисгүй хүрэх (татаж чангаах, гижигдэх, хазах, чимхэх, онцгой газруудаар илж таалах, гараа буюу эрхтнээ хүргэх, шүргүүлэх)
- ❖ Тэврэх, наалдах, үнсэх,

❖ Хоргоох, мөшгиж мөрдөх, довтолох, /хувцасыг нь урах, эд зүйлийг нь авч барьцаалах/

❖ Хүчээр бэлгийн харилцаанд орж хүчиндэх хүртэл үйлдлээр илэрдэг.





БОДИТ ТҮҮХ №3

Тухайн үед би сургуулиа төгсөөд үйлдвэрт, олон эрчүүдтэй салбарт орж ажиллаж байсан. Хажуугаар өнгөрсөн эрэгтэй бүр гэхэд хилсдэхгүй, намайг залуухан юм хэлж чадахгүй ичимхийг далимдуулан, дээрлэхэж байлаа. Элдэв санал тавина, урдуур гарахдаа хөх базаад авах, өнгөрөхдөө өгзөг рүү алгадах гээд л... Энэ доромжлолоос ангижрах гэсэндээ суух санал тавьсан ажлынхаа арай нэг итгэлтэй ахимаг насны хүнтэй суучиж билээ. Одоо бодоход хайртайдаа биш, тэр олон эрчүүдийн доромжлолоос ангижрах гэсэндээ тэр шүү дээ, мөн тэр хүнээр өөрийгөө хамгаалуулах байх гэж найдсан. Гэтэл тэр сонголт маань тэнэг сонголт байсан. Тэр сонголт миний амьдралын том алдаа байсан. Одооч харамсдаг...

■ ТАЙЛБАР:

АББД-ын энэ хэлбэр бодит байдал дээр хамгийн түгээмэл тохиолддог нь ХЭҮК-ийн 2005 онд хийсэн судалгаагаар нотлогдсон. Ер нь АББД-ын аливаа нэг хэлбэрт 2 эмэгтэй тутмын нэг нь өртдөг төдийгүй эрчүүд олонтой салбарт эрчүүд ч эрчүүддээ бэлгийн дарамт үзүүлдэг байна. Мөн энэ хэлбэрийн дарамт сурагч ахуйгаас эхлээд оюутан ахуй, хөдөлмөрийн бүх талбарт нийтлэг байна.

Дээрх жишээ бол насан туршын ханиа сонгох сонголтыг алдаанд хүргэсэн жишээ юм. Бэлгийн дарамтын аль ч хэлбэр хохирогчийг ганцаардах, сэтгэлээр унах, доромжлуулсан мэтээр мэдрэх, ажилдаа дур сонирхолгүй болох, ажлаа орхиход хүргэх олон муу үр дагавартай. Цаашлаад хүсээгүй бэлгийн харилцаа, үр хөндөлт, БЗДХ/ХДХВ/ДОХ, үргүйдэл, хүсээгүй хүүхэд гэх мэт олон сөрөг үр дагаврыг дагуулдаг.

Ер нь эрчүүд олонтой салбарууд болох цэрэг, цагдаа, хорих, зам барилгын ажлын салбаруудад АББД-аас сэргийлэх бодлого, хууль хэрэгжүүлэхийг ОУ-ийн хэмжээнд уриалан, үүнийг олон улс орнууд хэрэгжүүлсэн байдаг. Хүн бүр халдашгүй дархан гэх цаасан дээрх тунхаглалыг бодит байдалд хэрэгжих боломжтой болгон, бусдын бэлгийн орон зайд эрээ цээргүй халдах явдлыг зогсоох арга хэмжээг нэн даруй авах шаардлагатай байна.

Дараах зургууд нь Тэгвэл ингэнэ үгүй бол ...тэгнэ шүү /Quid Pro Quo/хэмээн дарамтлах ажлын байрны бэлгийн дарамтын хамгийн ноцтой хэлбэр юм.

Боловсролын орчинд




Ажил мэргэжлийн харилцаанд

Хэрэв чи надтай сайн харилцаатай байхын бол цалин мөнгө нэмэх, тушаал ахих гээд боломжууд байна ш дээ



Энэ тухай бодоорой.



Гараад тэгээд хүн бүрт олон юм яриад явбал чиний нэр хүнд л байхгүй болох байх шүү.



Таны нэр хүнд ч бас унах л байх




Чи овоо шазруун хүүхэн үү үгүй юу. Ажиллуулах үгүйг хэн шийддэгийг бас саначихсан нь дээр шүү чи.



Сумын засаг даргын байр


Хөөе Дүүриймаа,
сайхан инээмсэглээд л
зочдоо угтана
шүү дээ.



Наад хувцас
хунараа



За чи сайхан үйлчилнэ шүү,
сумын нэр баасдаг.



Өмнө нь ирсэн хүн чинь
унтий хэвтий гээд байсан,
би тэгж чадахгүй шүү

Уг нь төсөв хөрөнгө
батлагдахад хэрэгтэй дээ
Чи бодоорой



Эдгээр нь,

- ❖ Өндөр цалин, сайн дүн, аливаа бусад боломж санал болгож оронд нь бэлгийн таашаал үзүүлэхийг шаардах, дарамтлах.
- ❖ Тэгвэл ингэнэ үгүй бол.....хэмээн сүрдүүлж, ажлын байраа алдах, эсвэл эрсдэлтэй сонголт хийхэд хүргэх.
- ❖ Хүлээн аваагүй тохиолдолд нэр хүндийг нь унагах, элдэв яриа тараах, ажил хөдөлмөрийг нь шударгаар үнэлэхгүй байх, ажлаа орхиход хүргэх зэрэг ноцтой үр дагаваруудыг дагуулдаг.

БОДИТ ТҮҮХ №4

Манай хэлтсийн дарга чи надтай аятайхан байвал боломж чинь нэмэгдээд л байна шүү дээ гэх юм. Тэгээд шалтаг гаргаж ажилтай холбоотой холбоогүй байдлаар дуудаж уулздаг. Надад энэ бүхэн таалагдахгүй байгаа ба би дуудахад нь өрөөнд нь сүүлийн үед очихгүй байгаа. Саналыг нь хүлээж авахгүй гэдгээ ч хэлсэн. Одоо гэтэл илт гадуурхах үл тоох байдлаар харьцаж, намайг юм л бол хавчих боллоо. Би яавал дээр вэ?

■ ТАЙЛБАР:


Энэ хэлбэрийн бэлгийн дарамт мөн л нэлээд нийтлэг тохиолддог ба ихэнхдээ эрх мэдэл бүхий хүний зүгээс ирдэг дарамт гэдэг нь судалгаагаар харагдсан. Боловсролын тогтолцоонд ч оюутнуудын мэдлэгээ шударгаар дүгнүүлэхэд саад тушаа болсоор байгааг 2008 онд 648 оюутнуудын дунд явуулсан судалгаанаас харагдсан. Дээрх жишээ нь ажилтанд ажил хөдөлмөртөө анхаарч ажиллаж боломжийг хааж, хөдөлмөр эрхлэхтэй холбоогүй саналаас татгалзсаныхаа төлөө ажлаа алдах вий гэх айдаст хүргэж буйг харуулсан тохиолдлуудын нэг жишээ юм. Ийм айдастайгаар хэн ч ажлаа үр бүтээлтэй хийж чадахгүй. Энэ төрлийн дарамтын улмаас хөдөлмөрийн харилцааны эрх тэгш байдал алдагдах явдал их байдаг. Өөрөөр хэлбэл ажил хөдөлмөртэй холбоогүй, бэлгийн таашаал үзүүлэхийг тулгасан саналыг хүлээж аваагүй хүн хохирч байхад саналыг хүлээж авсан нэг нь хожих магадлал өндөр байгаа юм.

Ажлын байран дахь бэлгийн дарамтлал үйлдэгддэг газар

- ❖ Ажил, хөдөлмөр эрхэлж буй бүхий л орон зай, орчин,
- ❖ Суралцагчийн дадлага хийж буй сургалтын орчин,
- ❖ Дарга, удирдлагын дуудаж уулзаж буй өрөө, байр байгууламж,
- ❖ Түнш байгууллагын өрөө, байр байгууламж,
- ❖ Түнш байгууллагын дарга, удирдлагын ажлын шугамаар уулзахаар тохиролцсон өрөө, байр байгууламж,
- ❖ Томилолтоор явж буй унаа, тээврийн хэрэгсэл, ажлын өрөө, байрлаж буй буудал бусад өрөө, байр байгууламж,
- ❖ Хамт олноороо тэмдэглэлт үйл явдал тэмдэглэж буй газар, байр, буудал, унаа тээврийн хэрэгсэл, бусад,
- ❖ Тариалангийн талбай,
- ❖ Малын бэлчээр,
- ❖ Айлын гэр гэх мэт өргөн хүрээний ойлголт юм.
- ❖ Гэрийн үйлчлэгчээр болон гэрээ ажлын өрөө болгосон нөхцөлд ажиллаж буй бол хамаарна.



Хоюулаа машиндаа орж дулаацъя



АББД-н мөн чанар хор нөлөө /хувь хүнд/

Эргэлзээнд ордог ба хэн нэгэнд хэлэхээс эмээдэг

/Ажлаа өөрчлөх нь хэцүү мэт санагдах, дарамтлал үйлдэгчийн ятгалага буюу илүү цалин хөлс амлалт, нэр төрөө бодох, бусад хүмүүс муу хэлэхээс болгоомжлох зэрэг нь үнэн зөв шийдвэр гаргахад нөлөөлж, эргэлзээнд оруулдаг ба зарим тохиолдолд бүр эрсдэлтэй сонголт хийхэд аваачдаг байна./

Ганцаарддаг

/бүхнийг ганцаараа зохицуулж чадна гэж итгэсэн эсвэл хэнд ч хэлээд нэмэргүй гэсэн үзлээс болоод өөрийгөө тусгаарлаж, нэр төрөө хамгаалахыг оролддог. Гэсэн хэдий ч энэ байдал нь тус болдоггүй./

Уур уцаартай болдог

/Доромжлогдсон мэт сэтгэгдэлтэй үлдэж, түүнээсээ болоод эсрэг хүйсийн бүх л хүнийг үзэн ядахад хүрдэг/

Түгшүүрт автдаг

/ажилгүй болох вий, цалин хасах вий, үүнээс илүү ажил олдох болов уу гэх мэт түгшүүрт байдалд автаж ажлын бүтээмж нь буурдаг/

Ажлын байраа сольдог

/Ажлын байраа сольдог ба шинэ ажилд нь бас тийм байдал байх магадлалтай/

Нэр хүндгүй болдог

/Дуугүй өнгөрөх, дургүйцлээ илэрхийлэх 2-ын алийг нь сонгохоо шийдэж амжаагүй байдаг ба дургүйцсэн ч, дуугүй өнгөрсөн ч аль аль нь нэр төрд халтай байдаг. Дуугүй байвал дуртай хүүхэн гэж нэрлэгддэг, дуугарч аашилбал адсага шиг хүүхэн хэмээн ганцаардлыг амсдаг./

Зарим тохиолдолд өөрийгөө золиосолдог

/Үнэхээр өөр газар очоод ч ижил биз, тэвчээд үзье, хүлээн зөвшөөрөхөөс биш гэдэг шийдвэрт хүрч хохирдог/

АББД-н мөн чанар хор нөлөө /эрүүл мэндэд/

Элдэв өвчин эмгэгт өртөх магадлалтай /БЗДХ/ХДХВ/ДОХ

/Дарамтлалд өртөж буй хүний сонголт хийх нь ихэнхдээ хязгаарлагдмал байдаг. Ж нь: Ажлын байран дахь бэлгийн дарамтлалын биеэр илрэх хэлбэр, хүчингийн золиос болж буй хохирогч бэлгэвчийг санал болгох, бэлгэвч бэлэн байх нь бүтэмжтэй бил үү/

Хүсээгүй жирэмслэлт

/Эцэггүй хүүхэд. Эсвэл чамаас хүүхэдтэй болчихсон гэж хэлсний төлөө -Хэн мэдэх вэ хэний ч хүүхэд юм билээ гэх давхар дарамт доромжлол ирэх магадлалтай. Мөн хүүхэд өсгөх хүмүүжүүлэх том ажлыг дангаар үүрэх хариуцлага ирнэ/

Үр хөндөлт

/Эх нялхсын эрүүл мэнд, эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчин эмгэг, үргүйдэл бий болох магадлалтай/



АББД-н мөн чанар хор нөлөө /гэр бүлд/

Гэр бүлийн харилцаанд сэв суудаг.

/Бэлгийн дарамтлалд өртсөн тухай мэдээллийг гэр бүлийн хүн нь ихэнхдээ буруутгасан өнгө аясаар хүлээн авч, давхар гэр бүлийн дарамтлалд өртүүлэх тохиолдол байсаар байна/

Гэр бүл салалт, хүүхэд хүүхэд өнчрөх.

Орлогогүй болох, эдийн засгийн хямрал бий болох.

Гэмт хэрэгт холбогдох.

АББД-н мөн чанар хор нөлөө /байгууллагад/

Ажлын байрны ая тухтай байдал алдагдах.

Хөдөлмөрийн бүтээмж буурах.

Хөдөлмөрийн харилцаан дахь эрх тэгш байдал үгүй болох.

Байгууллагын нэр хүндэд муугаар нөлөөлөх.

Чадвартай боловсон хүчнээ алдах.

Байгууллагын ашиг орлого буурах зэрэг нөлөөтэй.

АББД-н мөн чанар хор нөлөө /нийгэмд/

Ажилгүйдэл нэмэгдэх.

Эдийн засгийн хямралд орох эрсдэл дагуулдаг.

/Хохирогчдын байдлаас харахад ажлаас шалтгаангүй халагдах, эргээд ажилд ороход ажлын байр хомс зэрэг нь хохирогчыг улам хүнд байдалд аваачдаг байна. Манай статистикт ажил эрхэлж буй 1 хүний цаана 1-3 тэжээлгэн тэтгүүлэгч байдаг тул энэ нь ганц хохирогч биш, гэр бүл цаашлаад нийгэмд ядуурал бий болох шалтгаан болж болзошгүй юм./





Channel
Foundation



АББД-тай тэмцэх Эмэгтэйчүүдийн ТББ-уудын Эвсэл



МУЭХ



Хүчирхийлэлийн эсрэг үндэслэлтэй тус



Иргэдийн алхамт тус



Хүний Эрх Хөгжил Тус
CHRD



Гал голомт төлөглөөн



Эмэгтэй уярагч сан



МАОЗХ



Монголын Хуульч
Эмэгтэйчүүдийн
Холбоо



Хүйсний тэгш
эрхийн тус



BER TSETSEG

Хаяг: Улаанбаатар-15160
Шуудангийн хайрцаг-2643
АББД-тай Тэмцэх ЭТББ-уудын Эвсэл.
Email хаяг: ag232616@yahoo.com
Face book хаяг: /www.facebook.com/abbdmongolia?ref=h1

Утас: 976-93090506
976-99032508
976-70119991